

БАТЛАВ
МӨНХИЙН ҮСЭГ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г. БОЛДБААТАР

БАТЛАВ
СҮИС ХҮС-ИЙН
ЗАХИРАЛ

Г. ГАНЦЭЦЭГ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны 09-р сарын 20

№ 47/М/09-133

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Мөнхийн Үсэг" ХХК түүнийг төлөөлж Маркетингийн менежер С.Түвшин-Эрдэнэ /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, нөгөө талаас санхүүжүүлэгч байгууллага: "Гонгорын Хайдав сан"-г төлөөлж /СҮИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль/ /цаашид "Захиалагч" гэх/ нар дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь "Монголын дуурийн хан хүү" номыг захиалга, зааварчилгааны дагуу "Мөнхийн Үсэг" ХХК хэвлэх үйлчилгээг үзүүлэх талаар хамтарч ажиллах тухай болон захиалагч нь Гүйцэтгэгчид гэрээнд заасан ажлын хөлс төлөх, талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Талууд бие биенийхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.
- 1.3 Гэрээний ХАВСРАЛТ үндэслэн захиалгад ажлыг гүйцэтгэнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээ нь 2017 оны 09-р сарын 20-ны өдрөөс 2017 оны 10-р сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 2.2 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх захиалгыг албан ёсоор хүлээн авч, эх загварыг захиалагчийн эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр баталгаажуулж өгснөөс хойш ажлын 7-10 /арван/ хоногийн дотор ажлыг гүйцэтгэнэ.

Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 3.1 Гүйцэтгэгч үнийн саналд өөрчлөлт оруулахаар бол захиалагчид албан ёсоор мэдэгдэж, харилцан тохиролцсон тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 3.2 Захиалагч болон гүйцэтгэгч талууд тохиролцон төлбөрийг дансаар ХААН банкин дахь 5038023019 дансанд шилжүүлгээр төлнө.
- 3.3 Захиалагч хэвлэлтийн захиалга өгөх тухай бүр 1 хоногт багтаан гэрээний нийт үнийн дүнгийн 70%-ийг гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн төлсөн байна.
- 3.4 Үлдэгдэл 30%-ийг бүтээгдэхүүн хүлээн авахдаа төлсөн байна.
- 3.5 Ажил хүлээлцэх акт үйлдсэний дараа засвар хийгдэх нөхцөлд засварлах ажлын хөлсийг тухайн үед талууд харилцан тохиролцоно.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Захиалагч хэвлүүлэх бүтээгдэхүүний батлагдсан эхийг хэвлэх тоо, цаасны төрөл, бусад хэмжээ, чанарын шаардлагыг заасан захиалгын хуудсыг гүйцэтгэгчид өгнө.

Энэхүү гэрээ нь тус 2 талын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувиаж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд Монгол Улсын хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

- 4.2 Гүйцэтгэгчийн ажлын явцын талаарх мэдээллийг авах, зааварчилга өгөх, хяналт тавих эрхтэй.
- 4.3 Хэвлэмэл бүтээгдэхүүний файлаа хэвлэлтэд оруулахаас өмнө гүйцэтгэгчийн гаргасан хар болон өнгөт пробыг сайтар хянан гарын үсгээр баталгаажуулна. Факс, и-мэйлээр явуулж болно.
- 4.4 Захиалсан бүтээгдэхүүний тоо хэмжээ дутсан, чанарын шаардлагыг хангаагүй тохиолдолд гүйцэтгэгчид мэдэгдэж засварлуулсаны дараа хүлээн авах эрхтэй.
- 4.5 Захиалагч гэрээт ажлын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд барагдуулах үүрэгтэй.
- 4.6 Захиалагч тал нь өөрийн хэвлэлтийн зөв бичгийн дүрмийн алдаа болон текст дээр гарсан агуулгын алдааг бүрэн хариуцна.
- 4.7 Захиалагч эх файлыг Indesign програм дээр 300 dpi-ээс багагүй, хар текст 100% black өнгөөр бэлтгэх, сэтгүүлийн 4-н талаас 0,5 мм-ийн огтлооны зай тавьж өгөх шаардлагатай.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1 Захиалагчаас өгсөн хэвлэлтийн эхийг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй.
- 5.2 Гүйцэтгэгч эхэд өнгөт болон хар проб гаргаж захиалагчаар хянуулан баталгаажуулна. Факс, и-мэйлээр явуулж болно.
- 5.3 Гүйцэтгэгч хэвлэлийн эхийг хүлээж авахдаа хэвлэлтийн технологиос шалтгаалан зайлшгүй хийх өөрчлөлтийг захиалагчтай зөвшилцөн хийнэ.
- 5.4 Гүйцэтгэгч хэвлэлийн эхэд зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулсан, өнгө нь зөрсөн, чанарын шаардлага хангахгүй гүйцэтгэсэн тохиолдолд алдаа доголдолыг 5-7 хоногийн дотор өөрийн зардлаар тухай бүрд нь арилган дахин гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.
- 5.5 Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн бус буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй бол ажил гүйцэтгэхэд гарч буй саад бэрхшээлийн талаар захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

Зургаа. Хариуцлага

- 6.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь гүйцэтгэлийн тодорхой хугацаа зааж бичгээр шаардлага тавих ба уг шаардлагыг биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг буруутай тал хариуцна.
- 6.2 Гүйцэтгэгч хэвлэлийн эхийг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,2%-тай тэнцэх алданги төлнө.
- 6.3 Захиалагч төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,2%-тай тэнцэх алданги төлнө.
- 6.4 Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцах үүрэгтэй.

Долоо. Бусад

- 7.1 Гэрээтэй холбогдон гарсан аливаа маргаан, үл ойлголцох байдлыг талууд харилцан тохиролцох, хүндэтгэлтэй байх зарчмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй нөхцөлд шүүхийн журмаар шийдвэрлэнэ.
- 7.2 Энэхүү гэрээг 2 эх хувиар үйлдэн гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болгох бөгөөд талуудад тус бүр нэг хувь хадгалагдана.

Энэхүү гэрээ нь тус 2 талын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувиаж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд Монгол Улсын хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

- 7.3 Гэрээний аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1 Давагдашгүй хүчин зүйл /гал түймэр, газар хөдлөлт, террорист үйлдэл, ажил хаялт г.м./-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлдлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.
- 8.2 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧ:	ЗАХИАЛАГЧ:
Мөнхийн Үсэг ХХК, Маркетингийн менежер /С.Түвшин-Эрдэнэ/ Хаяг: Хан-Уул дүүрэг 3-р хороо Ажилчны гудамж-135 Утас: 70140459, 99061740 Факс: 70141316 E-mail:	Хөгжмийн урлагийн сургуулийн Тэнхимийн эрхлэгч /Ц.Чулуунцэцэг/ Хаяг: Чингэлтэй дүүрэг, Бага Тойруу 26. Утас: 324762, 99139719 Факс: 325205 E-mail:
Ерөнхий санхүүч /Б.Баянчимэг	Ерөнхий санхүүч /ГОНГОРЫН ХАЙДАВ САН/- -г төлөөлж..... /Д.Өлзийсүрэн
	Утас: E-mail:

Энэхүү гэрээ нь тус 2 талын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувиаж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд Монгол Улсын хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн
... тоот гэрээний хавсралт

Хэвлэх ажлын захиалгын хуудас

№	Бүтээгдэхүүний нэр	хэмжээ	Үзүүлэлт	Тоо ширхэг	үнэ
1	Монголын дуурийн ханхүү ном	A4 /264 нүүр/	Цаас: 105 гр матт цаас Хавтас: хатуу хавтастай. Гадна талдаа 157 гр матт цаас. Супер хавтастай. Нэмэлт ажилбар: хавтас мөнгөн фольга дарна, супер хавтас 6С-лактай	500 ш	18 300 төг
Нийт				9 150 000 төгрөг	

Мөнхийн Үсэг ХХК,
Маркетингийн менежер
..... /С.Түвшин-Эрдэнэ/
Хаяг: СБД, Тэвэрчдийн гудамж,
Утас: 70140459, 99061740, 91111123
Факс: 70141316
E-mail: s.tuvshinerdene@gmail.com

ЗАХИАЛАГЧ:
Хөгжмийн урлагийн сургуулийн
Тэнхимийн эрхлэгч
..... /Ц.Чулуунцэцэг/
Хаяг: Чингэлтэй дүүрэг, Бага
Тойруу 26.
Утас: 324762, 99139719
Факс: 325205
E-mail:

Ерөнхий санхүүч
/ГОНГОРЫН ХАЙДАВ САН/-
-г төлөөлж.....
..... /Д.Өлзийсүрэн

Утас:
E-mail:

Энэхүү гэрээ нь тус 2 талын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувиаж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд Монгол Улсын хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.